



**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**Шударга иргэдийн нэгдсэн эвсэл  
намын улсын бүртгэлийн мэдээлэлд  
оруулсан өөрчлөлтийг бүртгэх тухай**

Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Г.Алтанчимэг, Ч.Тунгалаг, шүүгч Б.Амарбаясгалан, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Г.Банзрагч, П.Золзаяа, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намаас гаргасан тус намын улсын бүртгэл дэх мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг шүүгч Ц.Цогтын илтгэснээр хэлэлцээд

**ТОДОРХОЙЛОХ нь:**

Нэг. Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын даргаар сонгогдсон иргэн Ц.Гантулгаас 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдөр “тус намын дарга Ж.Батзандан нь намын даргаас чөлөөлөгдөх хүсэлтээ илэрхийлсэн ба Төрийн албаны тухай хуулийн 37.1.5-д заасны дагуу намын гишүүнээсээ түдгэлзсэн тул намын их хурлыг, Төв зөвлөлийн №09 тоот тогтоолоор зарлан, 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хуралдуулж, намын даргаар Ц.Гантулгыг сонгож, томилсныг бүртгэж өгнө үү” гэсэн хүсэлт бүхий өргөдөл гаргаж, өргөдөлдөө:

-Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын даргын бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлт,

-Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын Төв зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Намын их хурлыг товлох тухай” 09 дүгээр тогтоол,

-Ж.Батзандангийн 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн өргөдөл,

-Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын Их хурлын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын ээлжит 2 дугаар Их хурлын ирцийг баталгаажуулах тухай” 01 дүгээр тогтоол,

-Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын Их хурлын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын ээлжит 2 дугаар Их хурлын хэлэлцэх асуудлыг батлах тухай” 06 дугаар тогтоол,

-Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын Тооллогын комиссын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын ээлжит 2 дугаар Их хурлын санал хураалтын дүн” 01 дүгээр тогтоол,

-Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын даргыг чөлөөлөх, шинээр сонгох, батламжлах тухай” 07 дугаар тогтоол,

- Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын ээлжит 2 дугаар Их хурлын тэмдэглэл,

- Улсын бүртгэлийн гэрчилгээ /эх хувь/
- Улсын тэмдэгтийн хураамж 150,000 төгрөг тушаасан баримт
- Ц.Гантулгын иргэний үнэмлэхийн хуулбар болон холбогдох бусад баримтыг хавсарган ирүүлсэн байна.

Хоёр. Монгол Улсын Дээд шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “намын дарга Ж.Батзандан хүсэлт гаргасан хэдий ч түүнийг чөлөөлөх, шинээр намын дарга сонгох асуудлыг дүрэмд заасны дагуу намын их хурлаар хэлэлцэж шийдвэрлээгүй байна. Өөрөөр хэлбэл, намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийг эрх бүхий байгууллагаас томилоогүй бөгөөд хуулийн этгээдийн мэдээлэлд ямар өөрчлөлт оруулсан нь тодорхойгүй байна” гэсэн үндэслэлээр тус намын даргын өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсан байна.

Гурав. Мөн Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 3.10-т зааснаар хүсэлт гаргагч Ц.Гантулгыг оролцуулан сонсох ажиллагаа хийж холбогдох тодруулга, тайлбарыг авсны дагуу тус намаас 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр тайлбар, Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын 2 дугаар хурлын төлөөлөгчдийн ирцийн бүртгэлийг бичгээр болон тус хурлын явцын бичлэг, фото зураг зэргийг файлаар ирүүлсэн байна.

#### ҮНДЭСЛЭХ нь:

Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын даргаар Ц.Гантулга сонгогдсоныг улсын бүртгэл дэх тус намын удирдлагын мэдээлэлд бүртгэж шийдвэрлэв.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10-т зааснаар улс төрийн намын даргын буюу гүйцэтгэх удирдлагын өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлт нь улс төрийн намын улсын бүртгэл, хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулгад заавал тусгах мэдээлэлд хамаарч байна.

Улс төрийн намын “хуулийн этгээдийн мэдээлэл”-д оруулах өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.6, 15.1, 22.4-т заасны дагуу Улс төрийн намын тухай хууль болон тус намын дүрэмд нийцсэн эсэхийг хянах замаар шийдвэрлэнэ.

Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын Төв зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор намын Их хурлаа 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр зарлан хуралдуулсан нь тус намын дүрмийн 22 дугаар зүйлийн 22.2-т “Их хурлын хуралдаан нь ээлжит болон ээлжит бус байна. Ээлжит Их Хурлыг 4 жилд нэгээс доошгүй удаа “Төв зөвлөл” зарлан хуралдуулна. Их хурлын хуралдааны дэгийг тухайн их хурал өөрөө тогтооно” гэж заасантай нийцжээ.

Мөн тус намын дүрмийн 23.1-д “Дараах асуудлыг намын Их хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ”, 23.1.2-т “намын даргыг сонгох, чөлөөлөх” бүрэн эрхийг тус намын Их хуралд олгосон байгаа тул намын даргыг чөлөөлж, сонгох асуудал нь Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын Их хурлын эрх хэмжээнд хамаарч байна.

2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Их хуралд сонгогдсон гишүүдийн 71 хувь нь оролцож, Ж.Батзандангийн өөрийн хүсэлтээр намын даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг хэлэлцэн, тус намын даргаас чөлөөлж, мөн хуралд оролцсон гишүүдийн 91 хувийн саналаар Ц.Гантулгыг тус намын даргаар сонгожээ.

Энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 5.1.4-т “дотоод асуудлаа ардчилсан зарчмыг баримтлан олонхын саналаар шийдвэрлэх” зарчим, 14.1.4-т “хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагааныхаа зохион байгуулалтын бүтэц, зорилт, арга хэлбэрээ чөлөөтэй сонгох” зохицуулалтад болон тус намын дүрмийн 22.4-т “Их хурлын сонгогдсон төлөөлөгчдийн олонх нь хүрэлцэн ирснээр тухайн хурал хүчин төгөлдөр болно. Их хуралд оролцож буй төлөөлөгчдийн олонхын саналаар шийдвэр хүчинтэй болно” гэж заасантай нийцсэн байна.

Иймд, Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл Намын даргын өөрчлөлтийг тус намын улсын бүртгэлийн мэдээлэлд бүртгэх хууль зүйн үндэслэлтэй гэж нийт шүүгчийн хуралдаанаас үзсэн болно.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.6, 22.4-т заасныг баримтлан Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаар Их хурлаар тус намын даргаар Боржигон овгийн Цэндсүрэнгийн Гантулга (РД: ЕП78041813) сонгогдсон тухай өөрчлөлтийг Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл Намын улсын бүртгэлийн мэдээлэлд бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ